



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/63

Ховд

Хөрөнгө оруулалтын эрх шилжүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “а”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12 дугаар сарын 02-ний өдрийн аравдугаар хуралдааны 10/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 06 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтанд Хөшөөт хөгжил сангийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 3.11 дахь заалт Тагнуулын газрын байрны тавилга, тоног төхөөрөмж 15,0 сая төгрөгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулах эрхийг аймгийн Тагнуулын газрын дарга /С.Анхбаяр/-д шилжүүлсүгэй.

2. Эрх шилжсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зураг төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг үндэслэлтэй боловсруулж 2 дугаар сарын 20-ны дотор Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсээр хянуулан баталгаажуулсны үндсэн дээр, худалдан авах ажиллагааг 3 дугаар сарын 25-ны дотор холбогдох хууль, журмын дагуу ил тод, нээлтэй, шуурхай зохион байгуулж, гүйцэтгэгчийг шалгаруулан гэрээ байгуулж, ашиглалтанд хүлээн авах зэрэг арга хэмжээ авч, үр дүнг 8 дугаар сарын 20-ны дотор тайлагнахыг аймгийн Тагнуулын газрын дарга /С.Анхбаяр/-д даалгасугай.

3. Эрх шилжүүлж буй хөрөнгө оруулалтын захиалагчийн хяналтыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулахыг Хууль эрх зүйн хэлтсийн дарга /Н.Ганзориг/-д хариуцуулсугай.

[Type text]

Зах А/63.Ч  
02 00277

4. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавьж, өмч бүртгэлд тусгахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ш.Нохойжав/, холбогдох бичиг баримтын бүрдлийг хянаж санхүүжүүлж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ